

## **ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмын нэмэлт, өөрчлөлтийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага батална.
- 1.3 Журмын нэр томъёоны тодорхойлолт
  - 1.3.1 “Бирж” гэж Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;
  - 1.3.2 “Арилжааны мэдээ” гэж Арилжааны журмын 6 дугаар зүйлд заасныг;
  - 1.3.3 “Мэдээлэл хүсэгч” гэж Биржийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах хүсэлт гаргаж буй иргэн, хуулийн этгээдийг;
  - 1.3.4 “Цахим хуудас” гэж нийтэд нээлттэй байдлаар интернет сүлжээнд байрлуулсан цахим баримт бичгийг.

### **Хоёр. Олон нийтэд түгээх мэдээлэл**

- 2.1. Биржийн маркетинг, олон нийттэй харилцах мэргэжилтэн болон холбогдох албадууд Биржийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор мэдээллийг олон нийтэд түгээх дараах ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Биржийн арилжааны мэдээг Арилжааны журмын дагуу олон нийтэд мэдээлэх;
  - 2.1.2. Биржээр арилжсан бараа, түүхий эдийн ханшийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх;
  - 2.1.3. Биржийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбоотой хууль, дүрэм, журмыг цахим хуудсанд байршуулах;
  - 2.1.4. Биржээс зарласан сул ажлын байрны мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх;
  - 2.1.5. Биржийн тухайн жилийн санхүүгийн төсвийн гүйцэтгэлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд нээлттэй болгох;
  - 2.1.6. Тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэх;
  - 2.1.7. Хууль, тогтоомжид заасан бусад.
- 2.2. Биржийн Захиргааны албаны мэдээллийн технологийн ажилтан Биржийн олон нийтэд цахим хэлбэрээр мэдээ, мэдээлэл түгээх үйл ажиллагааг хариуцан ажиллана.

### **Гурав. Иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох мэдээлэл**

- 3.1. Бирж дараах тохиолдолд мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:
  - 3.1.1. Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсвэл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болохуйц нууц мэдээ, технологийн шийдэл,

төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээлэл;

- 3.1.2. Эрх бүхий этгээдээр хянан шалгагдаж буй мэдээлэл;
- 3.1.3. Хөдөө аж ахуйн биржийн нууц хамгаалах, нууц баримт бичигтэй ажиллах журмаар хориглосон мэдээлэл;
- 3.1.4. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай мэдээлэл;
- 3.1.5. Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээлэл;
- 3.1.6. Өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусад задруулахыг хориглосон оюуны өмчтэй холбоо бүхий мэдээлэл;
- 3.1.7. Хууль тогтоомжид заасан бусад.

#### **Дөрөв. Мэдээлэл хүсэгч**

- 4.1. Мэдээлэл хүсэгч нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол улсын хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
- 4.2. Мэдээлэл хүсэгч нь амаар, бичгээр болон цахим хэлбэрээр Биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах хүсэлтийг Биржид гаргаж болно.

#### **Тав. Хүсэлтийг хянан үзэх**

- 5.1. Биржийн маркетинг, олон нийттэй харилцах мэргэжилтэн мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч, дараах нөхцлийг хянан үзсэний үндсэн дээр мэдээлэл хүсэгчид тухайн мэдээллийг Бижээс өгөх эсэхийг шийдвэрлэнэ.
  - 5.1.1. Хүсэлтэд дурдсан мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байгаа эсэхийг нягтлах;
  - 5.1.2. Хүсэлтэд дурдсан мэдээлэл энэ журам болон хууль, тогтоомжоор хориглосон эсэх;
- 5.2. Энэ журмын 5.1.1 болон 5.1.2-т заасан үндэслэлээр Биржээс тухайн мэдээллийг гаргах боломжгүй тохиолдолд энэ тухай шалтгаан, үндэслэлийг хүсэлт гаргагчид өгөх тайлбарт тодорхой заана.

#### **Зургаа. Мэдээлэл өгөх**

- 6.1. Бирж нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдэд гаргаж өгнө.
- 6.2. Мэдээллийг амаар, бичгээр болон цахим хэлбэрээр өгч болно.
- 6.3. Биржийн тодорхой албан тушаалтнаас мэдээллийг аман хэлбэрээр авахаар хүсэлт гаргасан тохиолдолд тухайн албан тушаалтны ажлын ачааллыг харгалзан, Биржийн маркетинг, олон нийттэй харилцах мэргэжилтэн уулзалт, ярилцлагын газар, цагийг тодотгож, хүсэлт гаргагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 6.4. Мэдээллийг шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгнө.
- 6.5. Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор хариу өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.
- 6.6. Бирж шаардлагатай гэж үзвэл энэ журмын 6.5-д заасан хугацааг 7 хоногоор дахин сунгаж болно.
- 6.7. Мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор хүсэлт гаргаж буй иргэн, хуулийн этгээдээр мэдээллийн үнэн бодит байдлыг хангах баталгаа гаргуулсны үндсэн дээр тухайн мэдээллийг өгнө.
- 6.8. Энэ журмын 6.7-д заасан мэдээ, мэдээллийг Бирж шаардлагатай гэж үзвэл мэдээлэл хүсэгчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тухайн мэдээллийг өгч болно.

#### **Долоо. Тэмдэглэл хөтлөх**

- 7.1. Биржийн маркетинг, олон нийттэй харилцах мэргэжилтэн мэдээллийн хүсэлт тус бүрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд дараах зүйлийг тусгана.
  - 7.1.1. Мэдээлэл авах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;
  - 7.1.2. Мэдээлэл авах хүсэлт хүлээн авсан, хянасан буюу буцаасан, мэдээллийг өгсөн хугацаа;
  - 7.1.3. Мэдээлэл авах хүсэлтийн хариу бэлтгэсэн албан тушаалтны нэр;
  - 7.1.4. Мэдээлэл олгосон хэлбэр;
  - 7.1.5. Бусад.

#### **Найм. Хариуцлага**

- 8.1. Бирж энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 8.2. Энэ журмыг зөрчсөн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дотоод журмын 8 дугаар бүлэгт заасны дагуу хариуцлага тооцно.